



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ ЗҮЙ,
ДОТООД ХЭРГИЙН САЙД

15160 Улаанбаатар хот, Чингэлтэй дүүрэг,
Худалдааны гудамж 6/1, Засгийн газрын V байр,
Утас/Факс: (976-51) 26 75 33, E-mail: foreign@mojha.gov.mn,
<http://www.mojha.gov.mn>

2019.12.27 № 1-1/5793
танай 2019.12.19 -ны № 01/6766 -Т

ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН
САЙД Б.ЭНХ-АМГАЛАН ТАНАА

Зам, тээврийн хөгжлийн сайдын 2019 оны “Журамд нэмэлт оруулах тухай” 376 дугаар тушаалыг Захиргааны ерөнхий хууль болон холбогдох бусад хуулийн дагуу хянан үзэж, захиргааны хэм хэмжээний актын улсын нэгдсэн бүртгэлийн 4170 дугаарт бүртгэлтэй Монгол Улсын Шадар сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2018 оны “Журам шинэчлэн батлах тухай” 192 дугаар тушаалд холбогдох хөдөлгөөн хийснийг мэдэгдье.


Ц.НЯМДОРЖ

1119207523 ШТТ6740 9131817

151605533
Doc.yam a5.2019



Захиргааны хэм хэмжээний
актын улсын нэгдсэн санд
2019 оны 12 сарын 27-ны
өдөр хүлээн авсан.

МОНГОЛ УЛСЫН ЗАМ, ТЭЭВРИЙН ХӨГЖЛИЙН САЙДЫН ТУШААЛ

2019 оны 12 сарын 17 өдөр

Дугаар 376

Улаанбаатар хот

Журамд нэмэлт оруулах тухай


Монгол Улсын Засгийн газрын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 2, Автотээврийн тухай хуулийн 17¹ дүгээр зүйлийн 17^{1.2}, Захиргааны ерөнхий хуулийн 63 дугаар зүйлийн 63.1, 70 дугаар зүйлийн 70.1 дэх хэсэгт заасныг тус тус үндэслэн ТУШААХ нь:

Нэг. Замын хөдөлгөөний аюулгүй байдлыг хангах, хүний амь нас эрүүл мэндийг хамгаалах осол зөрчил гэмтлээс урьдчилан сэргийлэх, хойшлуулшгүй нэн даруй хэрэгжүүлэх ажлын хүрээнд Монгол Улсын Шадар сайд, Зам, тээврийн хөгжлийн сайдын үүргийг түр орлон гүйцэтгэгчийн 2018 оны 192 дугаар тушаалаар батлагдсан "Автотээврийн хэрэгслийн- бүртгэл хөтлөх, улсын дугаар олгох журам"-ын "2.7.7" дахь заалтын дараа "2.7.8. Автотээврийн хэрэгсэл экспортлогч улсын экспортлохоос өмнөх үеийн техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт" гэж, "4.3.12" дахь заалтын дараа "4.3.13. Авто тээврийн хэрэгсэл экспортлогч улсын экспортлохоос өмнөх үеийн техникийн хяналтын үзлэгийн дүгнэлт." гэж мөн журмын "3.9" дахь заалтын дараа "3.10. тухайн автотээврийн хэрэгслийн түүх агуулсан мэдээллийн сан бий болгож холбогдох улстай хамтран ажиллах ажлыг зохион байгуулах" гэж тус тус нэмсүгэй.

Хоёр. Журамд оруулсан нэмэлт заалтыг иргэд, аж ахуй нэгж байгууллагуудад сурталчилан таниулах ажлыг зохион байгуулж ажиллахыг Автотээврийн үндэсний төв ТӨҮГ /Б.Гүрсоронзон/-т даалгасугай.

Гурав. Журмын хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Автотээврийн бодлогын хэрэгжилтийг зохицуулах газар /Г.Гантулга/-т үүрэг болгосугай.

САЙД



Б.ЭНХ-АМГАЛАН

081156